

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 31-ны өдөр

Орхон аймаг

Д/д	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Хүрсэн түвшин	Биелэлт -ийн хувь
Ерөнхий чиг үүрэг-1: Олон Улсын дотоод аудитын тогтолцоог төлөвшүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх						
Үндсэн чиг үүрэг-1: Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дотоод дүрэм, журмыг шинэчлэх, сайжруулах, харилцагч байгууллагын уялдаа холбоо чадавхыг бэхжүүлэх						
1	Зорилт-1 Хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын холбогдох дүрэм, журамд шинэчлэлт, сайжруулалт хийх, харилцагч байгууллагуудт ай уялдаа холбоог сайжруулан ажиллах	Арга хэмжээ-1 Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг мөрдөх, шаардлагатай тохиолдолд дотоод дүрэм, журамд шинэчлэлт, сайжруулалтыг хийж, батлуулах	Хэрэгжилт-ийн хувь	100%	Засгийн газрын 2025.01.29-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг “Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар” болгон өөрчилсөнтэй холбоотой аймгийн Дотоод аудитын хороог 2025.04.30-ны өдөр хуралдуулж, хурлаар дараах дүрэм, журамд өөрчлөлт оруулан хэлэлцүүлж батлуулсан. Үүнд: 1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дүрэм 2. Дотоод аудит хийх журам 3. Санхүүгийн хяналт шалгалт хийх журам	100%
2		Арга хэмжээ-2 Төсвийн ерөнхийлөн захирагч, дээд шатны байгууллага, бусад байгууллагатай хамтран ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо	5	2025 онд 7 байгууллага тай шинээр хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтран ажиллалаа. Үүнд: 1. “Үндэсний дата төв” УТҮГ 2. Олон улсын стандартын академи ХХК 3. Таван богд нура ХХК 4. “Түшиг ЭНЖИБИ” ХХК 5. “Ворлд стандарт консалтинг” ХХК 6. “Наахай тур бус” ХХК 7. “МонСертф” ХХК Мөн Эрүүл мэндийн яаманд 9 байгууллага /Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нийцэл, Үйлсбадрах, Анхны-Оч, Энхжих мандарваа, Мэндцэцэн, Мөнхийн гэгээ,	100%

					Мөнхсүндэрэл, Учралтбаяр ӨЭМТөвүүд/, Боловсролын яаманд 10 байгууллага /7, 17 дугаар сургууль, 8, 23, 27, 28, Унага, Эрх бүжинхэн, Дэгдээхэй, Баян-Өндөр цэцэрлэгүүд/-д санхүүгийн хяналт шалгалт хийх хүсэлтийг тус тус хүргүүлэн хамтран ажилласан. Тус яамдаас ирсэн бичгийг үндэслэн “2025 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө”-д тусган хэрэгжилтийг ханган ажилласан.	
Биелэлтийн хувь						100%
Үндсэн чиг үүрэг-2: Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан хараат бус байдлыг дээшлүүлэх						
3	Зорилт-2 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын бие даасан хараат бус байдлыг дээшлүүлэх	Арга хэмжээ-1 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгтгэх, мэдээллийн санг баяжуулах	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	60	2025 онд төлөвлөгөөт 58 байгууллага, төлөвлөгөөт бус 16 байгууллага, нийт 74 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, шалгалт бүрэн дууссан 74 байгууллагын эрсдэлийг “Эрсдэлийн менежментийн журам”-ын дагуу үнэлж “Эрсдэлийн мэдээллийн сан”-д нэгтгэн ажиллалаа. Үүнд: ➢ “Хангалттай” үнэлэгдсэн 38 байгууллага ➢ “Сайжруулах шаардлагатай” 33 байгууллага ➢ “Хангалтгүй” 3 байгууллага /Хот тохижуулах газар, 20-р сургууль/ тус тус дүгнэгдлээ.	100%
4		Арга хэмжээ-2 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг эрсдэлийн үнэлгээнд суурилан төлөвлөж, стандартын дагуу үр дүнтэй, гүйцэтгэж, засаглалын эрсдэлийг бууруулах	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	60	Байгууллагын даргын 2020 оны А/17 дугаартай тушаалаар “Эрсдэлийн үнэлгээний журам”-ыг баталсан. Энэ журмаар их эрсдэлтэй байгууллагын жил тутам, дунд эрсдэлтэй байгууллагыг 1-2 жил тутамд, бага эрсдэлтэй үнэлэгдсэн байгууллагыг 2 жил тутамд 1 удаа хяналт шалгалтад хамруулахаар журамласан байдаг. Өмнөх онуудын эрсдэлийн үнэлгээнд суурилан байгууллагын 2025 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 60 байгууллагаас 2025 онд 58 байгууллагын хяналт шалгалтын удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулж, 58 байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан. Шалгалт бүрэн дууссан 58 байгууллагыг эрсдэлийг “Эрсдэлийн менежментийн журам”-ын дагуу үнэлж “Эрсдэлийн мэдээллийн сан”-д нэгтгэн ажиллалаа.	96%

					2025 онд аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2024 оны IV улирал, 2025 оны I улирал, 2025 оны II улирал, 2025 оны III улирлын байдлаар 4 удаагийн дотоод аудитыг гүйцэтгэн холбогдох байгууллагуудад нэгдсэн тайланг албан бичгээр хүргүүлсэн. Мөн “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан сайжруулах, арга зүйгээр хангах зорилгоор аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод хяналт, нягтлан бодогч нарт 5 удаагийн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.	
6		Арга хэмжээ-3 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын тоон тайланг нэгтгэх, дээд шатны байгууллагад хүргүүлэх	Жилд 2 удаа	2	2025 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын тоон мэдээг 2 удаа нэгтгэн дүгнэлээ. 2025 оны нэгтгэсэн тоон тайлангаар төлөвлөгөөт 58 байгууллага, төлөвлөгөөт бус 16 байгууллага нийт 74 байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэн 340 зөрчил илрүүлж, 95,484.7 мянган төгрөгийн 21 төлбөрийн акт, 4,833,978.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 46 албан шаардлага, ажил сайжруулах 21,508,718 мянган төгрөгийн өртөг бүхий 277 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн хяналт шалгалтын тоон мэдээ, бичмэл тайланг 2025.01.10-ны өдөр, 2025 оны эхний хагас жилийн хяналт шалгалтын тоон мэдээ, бичмэл тайланг 2025.07.10-ны өдөр тус тус Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2 удаа хүргүүлж ажилласан.	100%
7	Зорилт-3 Улс, орон нутгийн төсвийн хэмнэлттэй, зүй зохистой	Арга хэмжээ-1 Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллага, Засгийн газрын болон орон нутгийн тусгай	Хяналт шалгалтад хамрагдах байгууллагын тоо	5 байгууллага	2025 оны жилийн эцсийн байдлаар удирдах дээд шатны байгууллага, бусад төрийн байгууллага, иргэний өргөдөл гомдлын дагуу төлөвлөгөөт бус 16 удаагийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг аймгийн Засаг даргын батласан удирдамжийн хүрээнд гүйцэтгэн дүгнэлт өгч ажиллалаа. Үүнд:	100%

	зарцуулагдаж буй эсэхэд дүгнэлт өгөх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах	сан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, иргэний ирүүлсэн гомдлын дагуу төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт хийх			1. Нийтийн номын сангийн УУА-ны дарга, сан хөмрөгч Н.Отгонцагааны ирүүлсэн өргөдөл, гомдол: Аймгийн Засаг даргын 2025.01.15-ны өдрийн баталсан 05/25 дугаартай удирдамжийн хүрээнд “Нийтийн номын сан”-ийн төвийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. 2. Аймгийн Засаг даргын 2025.02.26-ны өдрийн баталсан 13/25 дугаартай удирдамжийн хүрээнд “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл”-ийг хариуцах нэгжийн 2024.01 дүгээр сараас-2025.02 дугаар сарын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаа, төслийн хэрэгжилт, үр дүн, Засаглалын удирдлага, Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын тогтолцоонд төлөвлөгөөт бус дотоод аудитыг гүйцэтгэлээ. Шалгалтаар төслийн хэрэгжүүлэх нэгжийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг “ХАНГАЛТГҮЙ” гэж дүгнэн 7 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. 3. Аймгийн Засаг даргын 2025.05.07-ны өдрийн баталсан 28/25 дугаартай удирдамжийн хүрээнд “Шинэ хөдөө” төслийн 2023, 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус дотоод аудитыг гүйцэтгэсэн. 4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025.06.03-ны өдрийн 05/2061 дугаар албан бичигт 20-р сургуулийн багш ажилчдаас тус сургуулийн захирал Д.Гантуулд холбогдох ёс зүйн зөрчил, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж буй талаар шалгаж, шийдвэрлүүлэх албан тоотыг үндэслэн аймгийн Засаг даргын 2025.06.04-ний өдрийн баталсан 36/25 дугаартай удирдамжийн хүрээнд “20-р сургууль”-ийн төсөв, санхүүтэй холбоотой 8 асуудлыг түүвэрлэн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн. 5. Аймгийн Засаг даргын 2025.06.05-ны өдрийн баталсан 37/25 дугаартай удирдамжийн хүрээнд Боловсролын газрын 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.	
--	--	---	--	--	--	--

					6. Аймгийн Засаг даргын 2025.06.04-ний өдрийн баталсан 35/25 дугаартай удирдамжийн хүрээнд Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн. 7. Аймгийн Засаг даргын 2025.10.03-ны өдрийн баталсан 53/25 дугаартай удирдамжийн хүрээнд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. 8. Аймгийн Засаг даргын 2025.10.03-ны өдрийн баталсан 54/25 дугаартай удирдамжийн хүрээнд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Болзошгүй аваарын зардлын 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. 9. Аймгийн Засаг даргын 2025.10.20-ны өдрийн баталсан 56/25 дугаартай удирдамжийн хүрээнд Жаргалант ус дулааны станцын 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. 10. Аймгийн Засаг даргын 2025.10.20-ны өдрийн баталсан 57/25 дугаартай удирдамжийн хүрээнд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. 11. Аймгийн Засаг даргын 2025.10.20-ны өдрийн баталсан 58/25 дугаартай удирдамжийн хүрээнд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын “Засаг даргын нөөц сан”-ийн 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. 12. Аймгийн Засаг даргын 2025.11.27-ны өдрийн 66/25 дугаартай удирдамжаар Хот тохижуулах газрын 2025 оны авто замын нөхөөсийн ажилд санхүүгийн хяналт шалгалт 13. Аймгийн Засаг даргын 2025.12.03-ны өдрийн 69/25 дугаартай удирдамжаар “Аймгийн Засаг даргын	
--	--	--	--	--	---	--

					эрхлэх асуудлын хүрээний төрийн албан хаагч болон зөвлөл хороо, ажлын хэсэг, комиссын гишүүдэд олгосон нэмэгдэл цалин хөлс, урамшуулал"-ийн 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт 14. Аймгийн Засаг даргын 2025.12.08-ны өдрийн 71/25 дугаартай удирдамжаар Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний чанар, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зэрэг чиглэлийг хамруулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит 15. Аймгийн Засаг даргын 2025.12.08-ны өдрийн 71/25 дугаартай удирдамжаар Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний чанар, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зэрэг чиглэлийг хамруулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит 16. Аймгийн Засаг даргын 2025.12.08-ны өдрийн 71/25 дугаартай удирдамжаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв-ийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний чанар, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зэрэг чиглэлийг хамруулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит Төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүү хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг холбогдох газруудад албан бичгээр, хариуцсан байгууллагын удирдлага, нягтлан бодогч, холбогдох ажилчдад танилцуулж, зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэх талаар үүрэг болгон ажиллалаа.	
8	Зорилт-4	Арга хэмжээ-1	Хэрэгжилт-ийн хувь	98%	2025 онд Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн	98%

	Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах	Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит гүйцэтгэх			хэрэгжилтэд 2024 оны IV улирал, 2025 оны I, II, III улирлын байдлаар 4 удаа дотоод аудит гүйцэтгэлээ. Дотоод аудитын дүнг танилцуулбал: 1. 2024 оны IV улиралд: - нэгдсэн дүн-99% - хугацаандаа мэдээлсэн байдал-99.3% - иж бүрэн мэдээлсэн байдал-99.6% 2. 2025 оны I улиралд: - нэгдсэн дүн-98.5% - хугацаандаа мэдээлсэн байдал-99.2% - иж бүрэн мэдээлсэн байдал-99.3% 3. 2025 оны II улиралд: - нэгдсэн дүн-98.1% - хугацаандаа мэдээлсэн байдал-99.4% - иж бүрэн мэдээлсэн байдал-98.4% 4. 2025 оны III улиралд: - нэгдсэн дүн-98.4% - хугацаандаа мэдээлсэн байдал-97.9% - иж бүрэн мэдээлсэн байдал-99.5% Дотоод аудитын нэгдсэн тайланг улирал бүр Сангийн яам, аймгийн ИТХ, Засаг дарга, Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга, ЗДТГ-ын СТСХ-т, мөн Боловсролын газарт ЕБС, СӨБ-ийн тайлан, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт Соёлын байгууллагын тайланг нэгтгэн тус тус албан бичгээр хүргүүлэн ажилласан.	
9		Арга хэмжээ-2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан хуулийн хэрэгжилтийг сайжруулах, мэдээлэл	Сургалтад хамрагдах байгууллагын тоо	84	“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан сайжруулах, арга зүйгээр хангах зорилгоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 157 байгууллагын 350 албан хаагчид хамрагдлаа. Үүнд: 1. 2025.05.28-ны өдөр Хувийн хэвшлийн 10 сургууль, цэцэрлэгийн 10 нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт Шилэн дансны тухай хуулийг сурталчлан,	100%

		оруулагч нарыг арга зүйгээр хангах			нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулалтыг сайжруулах арга зүй” сэдэвт практик сургалт; 2. 2025.05.29-ны өдөр улс, орон нутгийн төсөвт 3 байгууллагын шинээр томилогдсон 3 мэдээлэл оруулагч, нягтлан бодогч нарт “Шилэн дансны тухай хуулийн танилцуулга, нэмэлт өөрчлөлт, нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулалтыг сайжруулах арга зүй” сэдэвт практик сургалт; 3. 2025.05.28-ны өдөр аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 62 байгууллагын 21 удирдлага, 57 нягтлан бодогч, мэдээлэл оруулагч, 18 Эрсдэл, Дотоод хяналт хариуцсан ажилтнуудад “Шилэн дансны нэгдсэн цахим систем”-д мэдээлэл байршуулах арга зүй, илэрсэн нийтлэг зөрчил дутагдал, арга зүйн зөвлөгөөг өгч, Дотоод аудитын үр нөлөө, Засаглал, Эрсдэл, дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг үнэлэх замаар байнгын сайжруулалтыг төлөвлөх арга зүй сэдэвт цахим сургалтыг зохион байгуулсан. 4. 2025.10.28-ны өдөр аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй хамтран аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагуудын дарга, нягтлан бодогч, мэдээлэл оруулагчдад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн 2024 оны 4-р улирал, 2025 оны 1, 2, 3-р улирлын дотоод аудитын дүн, нийтлэг зөрчил, дүгнэлт”, “2026 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэх аргачлал, анхаарах зүйлс”, “Засаглал, эрсдэл, дотоод хяналтын тогтолцооны төлөвшил”, “Байгууллагуудад Эрсдэлд суурилсан Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит гүйцэтгэх”, “Төрийн сангийн удирдлагын цахим системийн шинэчлэл” зэрэг сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 82 байгууллагын 215 удирдах ажилтан буюу дарга, нягтлан бодогчид, эрсдэл, дотоод хяналт хариуцсан ажилтнууд 5. 2025.11.28-ны өдөр Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран “Шилэн дансны цахим системээс хэрхэн мэдээлэл татаж авах” сэдэвт сургалтыг зохион	
--	--	------------------------------------	--	--	--	--

					байгууллаа. Сургалтад Баян-Өндөр сумын Багийн Засаг дарга нар буюу 26 албан хаагч Мөн ажлын байранд 43 удаагийн ганцаарчилсан зөвлөгөө өгч, 25 байгууллагын нягтлан бодогчдод утсаар мэдээлэл өгч, арга зүйгээр хангаж ажилласан байна.																																	
Биелэлтийн хувь						99%																																
Ерөнхий чиг үүрэг-2: Монгол Улсын төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах																																						
Үндсэн чиг үүрэг-3: Байгууллагын хэмжээний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах																																						
10	Зорилт-5 Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах	Арга хэмжээ-1 Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилт-ийн хувь	98%	Байгууллагын 2025 оны хяналтад байгаа Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Хэрэгжээгүй болон биелэлт тасарсан, удааширсан тогтоол шийдвэр байхгүй. 2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын мэдээллийн санд бүртгэлтэй, хяналтад авсан 20 тогтоол, шийдвэр байна.Үүнд: <table><tr><td>№</td><td>Тогтоол, шийдвэр</td><td>Тоо</td><td>Хяналтад авсан заалтын тоо</td></tr><tr><td>1</td><td>Ерөнхийлөгчийн зарлиг</td><td>1</td><td>2</td></tr><tr><td>2</td><td>Улсын Их Хурлын тогтоол</td><td>2</td><td>3</td></tr><tr><td>3</td><td>Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол</td><td>2</td><td>5</td></tr><tr><td>4</td><td>Монгол улсын Засгийн газрын тогтоол</td><td>5</td><td>5</td></tr><tr><td>5</td><td>Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</td><td>5</td><td>8</td></tr><tr><td>6</td><td>Засгийн газрын албан даалгавар</td><td>5</td><td>13</td></tr><tr><td colspan="2">Нийт дүн</td><td>20</td><td>36</td></tr></table> Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурал, Улсын Их хурлын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хагас,	№	Тогтоол, шийдвэр	Тоо	Хяналтад авсан заалтын тоо	1	Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	2	Улсын Их Хурлын тогтоол	2	3	3	Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	2	5	4	Монгол улсын Засгийн газрын тогтоол	5	5	5	Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	5	8	6	Засгийн газрын албан даалгавар	5	13	Нийт дүн		20	36	100%
№	Тогтоол, шийдвэр	Тоо	Хяналтад авсан заалтын тоо																																			
1	Ерөнхийлөгчийн зарлиг	1	2																																			
2	Улсын Их Хурлын тогтоол	2	3																																			
3	Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	2	5																																			
4	Монгол улсын Засгийн газрын тогтоол	5	5																																			
5	Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	5	8																																			
6	Засгийн газрын албан даалгавар	5	13																																			
Нийт дүн		20	36																																			

					бүтэн жилээр 2 удаа, Засгийн газрын албан даалгаврын биелэлтийг сар бүр тогтоосон хугацаанд цахим системд оруулж ажилласан. Мөн аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т и-оффис системээр 2 удаа хүргүүлж ажилласан.	
11		Арга хэмжээ-2 Аймгийн ИТХ болон зөвлөлийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилт-ийн хувь	100%	2025 онд хяналтад байгаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралдааны 1 тэмдэглэлийн хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Үүнд: 1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл /2022.10 .21-ний өдрийн/ Хэрэгжилт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2025 онд 4 удаагийн дотоод аудитыг гүйцэтгэн холбогдох байгууллагуудад болон аймгийн ИТХ-д нэгдсэн тайланг албан бичгээр хүргүүлж ажиллалаа. Мөн Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах, сургалт мэдээллээр дамжуулан сайжруулах, арга зүйгээр хангах зорилгоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан. 2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол /Журам батлах тухай 2013.12.12-ны өдрийн 159 дугаар тогтоол/ Хэрэгжилт: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд байгууллагын даргын 2025 оны А/26, А/50 дугаартай тушаалаар байгууллагын “Эд, хөрөнгийн тооллогын комисс” хагас, бүтэн жилд 2 удаа томилж, тооллогыг 2 удаа зохион байгуулсан. Байгууллагын эд хөрөнгийг албан хаагчдын хөрөнгийн карттай тулган нэмэлт, өөрчлөлтийг хийлээ. Мөн албан хаагчдад хөрөнгийн ашиглалтад, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зөвлөгөө, зөвлөмжийг тогтмол өгч ажилласан. 3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол /Журам батлах тухай 2017.04.28–ны өдрийн 49 дугаар тогтоол/ Хэрэгжилт: 2025.05.16-ны өдрийн 94 дугаартай албан бичгээр “Орон нутгийн өмчийн газар”-т 4 ширхэг 3,064.6 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг актлах	100%

					саналыг хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2025.08.27-ны өдрийн А/709 дугаартай “Хөрөнгө акталж данснаас хасах” захирамж гарч, байгууллагын үндсэн хөрөнгийн данснаас хассан. 2025 оны хагас, бүтэн жилийн биелэлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.	
12		Арга хэмжээ-3 “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан хамаарах заалтын хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилт-ийн хувь	100%	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох “Хүний эрхэд суурилсан засаглал” бүлгийн Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдлын 4.2.1.1, Цахим засаглал, төрийн үйлчилгээний 4.3.1.5, 4.3.1.6 дахь нийт 3 зорилтын хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Үүнд: 1. Арга хэмжээ-1: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны www.shilen.gov.mn сайтад нийтлэгддэг “ Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ ”-ээр 2025 оны I улиралд 98%, II улиралд 97%, III улиралд 98%-тай тус тус үнэлэгдсэн. 2. Арга хэмжээ-2: Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 53 удаагийн сургалтад давхардсан тоогоор 305 албан хаагчийг хамруулж, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, сургалт мэдээллээр тогтмол, ханган ажилласан. 3. Арга хэмжээ-3: Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 100% ханган ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гомдол ирээгүй. Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулахад Ёс зүйн дэд хороо идэвх санаачилгатай ажиллалаа. 2025 оны хагас, бүтэн жилийн биелэлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тогтоосон хугацаанд хүргүүлсэн.	100%
13	Зорилт-6 Нэгдсэн менежмент-ийн	Арга хэмжээ-4 Нэгдсэн менежментийн тогтолцооны	Аудитад хамрагдах	Баталгаа -жуулах аудитад хамрагдсан.	“Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд байнгын сайжруулалт хийх ажлын төлөвлөгөө”-д тусгагдсан Чанарын менежментийн тогтолцооны ISO	100%

	тогтолцоог төлөвшүүлж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалтыг хийх	ISO 9001:2015, ISO 37001:2016 стандартуудын хэрэгжилтэд байнгын сайжруулалтыг төлөвлөх			9001:2015 Олон улсын стандарт, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын хэрэгжилтийг тус тус 100% ханган ажилласан. “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-ны хэрэгжилтэд стандарт баталгаажуулалтын “МонСертф” ХХК-аар 2025.11.05-07-ны өдрүүдэд аудит хийлгэж, Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах-1 аудит, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын магадлах-2 аудит, Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын анхдагч аудитад тус тус амжилттай хамрагдлаа. Аудитаар нийт 164 шалгуур үзүүлэлтээр дүгнүүлээ. Энэ онд Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын баталгаажуулах аудитад амжилттай хамрагдснаар 3 стандарт хэрэгжүүлэгч байгууллага боллоо.																			
Биелэлтийн хувь						100%																		
Ерөнхий чиг үүрэг-3: Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх																								
Үндсэн чиг үүрэг-4: Өсөн дэвжих эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх																								
14	Зорилт-7 Өсөн дэвжих эрмэлзэлтэй, чадахуйн зарчимд суурилсан, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх	Арга хэмжээ-1 Албан хаагчдыг мэргэшүүлэх болон бусад сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх	Сургалтын тоо	38	Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган, байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг 100% ханган ажилласан. <table><tr><th>№</th><th>Хэнд</th><th>Хаанаас</th><th>Сургалтын тоо</th><th>Албан хаагчдын оролцоо /тоо/</th><th>Хугацаа /цагаар/</th></tr><tr><td>1</td><td>Албан хаагчдад чиглэсэн</td><td>Дээд газраас зохион байгуулсан сургалт</td><td>26</td><td>62</td><td>54.5</td></tr><tr><td>2</td><td></td><td>Дотооддоо зохион байгуулсан сургалт</td><td>27</td><td>261</td><td>41.1</td></tr></table>	№	Хэнд	Хаанаас	Сургалтын тоо	Албан хаагчдын оролцоо /тоо/	Хугацаа /цагаар/	1	Албан хаагчдад чиглэсэн	Дээд газраас зохион байгуулсан сургалт	26	62	54.5	2		Дотооддоо зохион байгуулсан сургалт	27	261	41.1	100%
№	Хэнд	Хаанаас	Сургалтын тоо	Албан хаагчдын оролцоо /тоо/	Хугацаа /цагаар/																			
1	Албан хаагчдад чиглэсэн	Дээд газраас зохион байгуулсан сургалт	26	62	54.5																			
2		Дотооддоо зохион байгуулсан сургалт	27	261	41.1																			

					3	Зөвлөгөөн, форумд оролцсон	6	14	90	
					Хэсгийн дүн		59	337	185.6	
15		Арга хэмжээ-2 Улсын салбарын дотоод аудитын стандарт, Санхүүгийн хяналт шалгалтын стандарт, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын чиглэлээр албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	3	Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын чиглэлээр Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, Дотоод аудиторуудыг сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 31 албан хаагчдыг хамруулж ажиллалаа. Үүнд: ➢ 2025.03.21-ний өдөр Улаанбаатар хотод “Дотоод аудиторуудын институт”-тэй гэрээ байгуулж, багш Ж.Жаргалсүрэнгээс Засаглах удирдлага, гүйцэтгэх удирдлага, хараат бус дотоод аудитын талаар дэлгэрэнгүй ойлголт авч, “Жаргалант ус, дулаан түгээх станц” ОНӨХК-нд хийсэн дотоод аудитын тайланд үндэслэн дадлага ажил хийж, бодит кейс дээр ажиллан харилцан мэдээлэл солилцож, зөвлөгөө зөвлөмж авсан. Сургалтад байгууллагын бүх албан хаагч ➢ Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын газраас санаачлан Монгол улсын Сангийн яамтай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулсан Дотоод аудитор, СХШУБ (СХШУАБ) нарыг чадавхжуулах, мэдлэг мэдээлэл солилцох “Үзүүлэх сургалт”-д байгууллагын 4 албан хаагч ➢ Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран 2025.05.29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хамтын хөгжил-Сайн туршлага” сэдэвт зөвлөгөөнд 2 албан хаагч ➢ Улаанбаатар хотод 2025.11.13-2025.11.14- ний өдрүүдэд Сангийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран зохион байгуулж “Улсын салбарын дотоод аудиторуудыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох” зөвлөгөөнд Газрын дарга оролцлоо. Мөн 10 албан хаагч цахимаар хамрагдлаа.					100%

					➤ Улаанбаатар хотод 2025.11.19-ны өдөр зохион байгуулагдсан “Дотоод аудитуудын форум”-д 3 албан хаагч	
16	Зорилт-8 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх	Арга хэмжээ-1 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	95%	Төрийн албаны тухай хуулийн хүрээнд “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг 2025 онд 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар 100% ханган ажиллалаа. Үүнд: Онцлох ажлаас дурдвал: ➤ Орхон аймгийн Улаан загалмайн хорооны “Ивээн тэтгэгч” гишүүнээр хамтран ажилладаг. 2025 оны хамтын ажиллагааны хүрээнд 1 албан хаагчийн гэр бүлийн 1 хүнийг “Нүдний болор солиулах” хагалгаа, эмчилгээнд хамруулсан. Хагалгаа, эмчилгээний зардлыг Улаан загалмайн нийгэмлэгээс бүрэн шийдвэрлэсэн. ➤ 2025 оны 3-р сард Улаанбаатар хотын “Таван богд Нура” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрт илрүүлэг 11 албан хаагч 10,780.0 мянган төгрөгөөр хамруулсан. ➤ Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар Монголын уламжлалт “Цагаан сарын баяр”, “Ахмадын баяр”-ыг тохиолдуулан 4 ахмад настанд нийт 800.0 мянган төгрөгийн тэтгэмж олголоо. ➤ Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр нийт 32.5 сая. төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч албан хаагчдын өрөө тасалгааны тохижилт хийсэн. ➤ Албан хаагчдыг мэргэжүүлэх, ажлын байран хөгжил чиглэлээр тогтмол ажлын байранд болон дээд шатны байгууллага, мэргэжлийн холбоод, сургагч багш нартай хамтран төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байна. ➤ Албан хаагчдын хүүхдүүдийн дугуйлан, секц, хөгжлийн хөтөлбөрт хамрагддаг судалгааг гаргаж, 1 албан хаагчийн 1 хүүхэд буюу нийт 11 хүүхдэд тус бүр 100.0 мянган төгрөг, нийт 1,100.0 мянган төгрөгийн секц, дугуйлангийн төлбөр, 1 хүүхдэд “Таеквандогийн	100%

					Олон улсын тэмцээн"-д оролцоход нь 800.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж, "Түшиг Эн Жи Би" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан 1,842.0 мянган төгрөгийн зардлыг шийдвэрлэн 12 хүүхдийг "Генетик тест"-ийн оношилгоонд хамруулсан. ➤ Байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, соёлын хөтөлбөрийн хүрээнд 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг "ХАНГАЛТТАЙ САЙН" дүгнүүлсэн, мөн албан хаагч бүр Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилээр "ХАНГАЛТТАЙ" дүгнүүлсэн тул байгууллагаас 3,000.0 мянган төгрөгийн зардлыг шийдвэрлэн "Манжуур-Хайлаар хотын аялал"-д 2025 оны 09 дүгээр сард 8 албан хаагч, мөн удирдлагын түвшинд 16,600.0 мянган төгрөгийн зардлыг аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраар шийдвэрлүүлж, 2025 оны 10 дугаар сард "Эрэн-Жининь аялал"-д 3 албан хаагч, "Хайнан арлын аялал"-д 5 албан хаагчийг хамруулан урамшуулж, ажиллалаа. 2025 онд хөтөлбөрийн биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр 2 удаа аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т цахимаар болон цаасаар хүргүүлсэн.	
Биелэлтийн хувь:						100%
Ерөнхий чиг үүрэг-4: Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах						
Үндсэн чиг үүрэг-5: Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг ханган ажиллах						
17	Зорилт-9 Байгууллагын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах	Арга хэмжээ-1 Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах	Хэрэгжилт-ийн хувь	85%	2025 онд байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд дараах сувгуудаар дамжуулан мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллалаа. Үүнд: - Байгууллагын http://sankhuu.orkhon.gov.mn/ цахим хуудсанд 119 удаагийн мэдээ, мэдээллийг байршуулсан. "Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба" фэйсбүүк пэйж хуудсанд 61 удаагийн шинэ постер мэдээ бэлтгэсэн мөн 82 удаагийн мэдээ, мэдээллийг шэйр хийсэн.	100%

					3. Ил тод байдлын самбарт байгууллагын 2025 оны батлагдсан төсөв 1 удаа, бүтэц, орон тоо 1 удаа, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ 11 удаа, сар бүрийн үйл ажиллагааны тайлан 11 удаа зэрэг мэдээллүүдийг тухай бүр буюу нийт 24 удаа 4. “Шилэн дансны тухай хууль”-ийг сурталчлах, хэрэгжилтийг хангаж ажилласан тухай мэдээ, мэдээллийг бэлтгэн “Тусгал” телевиз, Uptate.mn сайтад 2 удаа дамжуулан иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажилласан.		
18		Арга хэмжээ-2 И-оффис системийн ашиглалтыг сайжруулах	Систем бүртгэсэн бүртгэлийн тоо	Ирсэн бичиг-243, явсан бичиг-249, албан хаагчдын ажлын төлөвлөгөө-458, өргөдөл гомдол-48, үүрэг даалгавар-70,	Байгууллагын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр И-Оффис системийн ашиглалт, бүртгэлийн тоо 937 байна. Үүнд: - Тушаал-79 - Явсан бичиг- 213 - Ирсэн бичиг-224 - Өргөдөл гомдол-32 - Хурлын болон газрын даргаас өгсөн үүрэг даалгавар-24 - Албан хаагчдын ажлын төлөвлөгөө-355 - Дотоод зар, мэдээ, мэдээлэл байршуулсан тоо - 10	100%	
19		Арга хэмжээ-3 Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn цахим системийн ашиглалтыг сайжруулах	Хэрэгжилт-ийн хувь	84%	Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам” мөн 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад 2025 оны I, II, III, IV улиралд тус бүр 5 бүлгийн 87 талбарт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг 4 удаа байршуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны www.shilen.gov.mn сайтад нийтлэгддэг “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ”-ээр 2025 оны I улиралд 98%, 2025 оны II улиралд 97%, 2025 оны III улиралд 98%, IV улиралд 98%-тай тус тус үнэлэгдсэн.	100%	
Биелэлтийн хувь:							100%
Нийт биелэлтийн хувь							99.75%

ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Д.САЙЗМАА

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ДОТООД АУДИТОР-
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Л.БУЛГАНЦЭЦЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

П.ДАВААЖАРГАЛ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

БҮЛЭГ ХОЁР: МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөөний бүлэг	Шийдвэрийн агуулга	Хэрэгжилтийн тайлан	Биелэлт -ийн хувь
1	2	3	4	5
2.1. ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХУУЛИАР ОЛГОСОН ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:				
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг /Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023.06.10 №88/	1.Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих;	Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн хүрээнд 2024 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагад 1 удаа дотоод аудитыг гүйцэтгэж, 2 зөрчлийг илрүүлсэн байна. Дотоод аудитаар нийт 84 байгууллагаас 33-байгууллага 100%, 28-байгууллага 95-99%, 18 байгууллага 90-94%, 5 байгууллага 80-89%-тай дүгнэгдсэн. 2024 онд Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/845 дугаар захирамжаар Худалдан авах ажиллагааны газар байгуулагдсан. Мөн Баян-Өндөр цэцэрлэг 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлэн, Шилэн дансны нэгдсэн цахим системд 2024 оны 02 дугаар сард цэс үүссэн. 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар байгууллагуудын цаг хугацаандаа мэдээлэл байршуулсан байдал 99.4 хувь, иж бүрэн, үнэн зөв мэдээлсэн байдал 97.2 хувь, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгдсэн дүн 96.6 хувьтай дүгнэгдлээ.	100%

2		2.Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих иргэний хяналтын тогтолцоо хийгээд өнөөгийн эрх зүйн орчины талаар олон нийтэд сурталчилах, иргэдийн санал дүгнэлтийг хүлээн авсан эсэхийг эргэж мэдэгдэж байх тогтолцоог нэвтрүүлэх.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, сурталчлах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: - Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулах эрх бүхий албан хаагчдад зориулсан 1 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, сургалтад 50 байгууллагын албан хаагч хамрагдлаа. - Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулдаг албан хаагчдыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, http://sankhuu.orkhon.gov.mn/, Orkhon turiin san цахим хуудас, төрийн байгууллагын нэгдсэн И-Оффис цахим системээр дамжуулан мэдээлэл байршуулах талаар цаг үеийн мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийн талаар "Тусгал" телевизэд 2 удаагийн ярилцлага өгсөн.	100%
3	Монгол Улсын Их Хурлын тогтоол /Чиглэл өгөх тухай 2014.05.01 №15/	1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хэрэгжих боломжгүй төсөл сонгон шалгаруулсан болон төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох	2024 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын төлөвлөгөөнд Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан, Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сангийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийхээр төлөвлөсөн бөгөөд уг дотоод аудит сүүлийн хагас жилд хийгдэнэ.	100%
4		2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэхээр гэрээ байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн зөрчлийг хянан үзэж, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журам, худалдан авах ажиллагаатай холбоотой журмуудын хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэсэн байна. Дотоод аудитаар сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Болзошгүй аваарын зардал" гэж хуваарилан хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт болон орон нутгийн иргэдийн саналын эрэмбэд	100%

			ороогүй дараах 12 ажлын гүйцэтгэлд нийт 209,009.4 мянган төгрөгөөр зарцуулсан, 2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд мэдээлбэл зохих мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, удирдамжгүйгээр хяналт шалгалтыг зохион байгуулсан зэрэг 3 зөрчил илэрсэн тул тус сангийн 2023 оны үйл ажиллагааг САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ гэж дүгнэн, 1 албан шаардлага, ажмил сайжруулах 3 зөвлөмж хүргүүлсэн байна. Цаашид аудитаар илэрсэн асуудалд анхаарч, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилтийг ханган ажиллах, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажлуудыг санхүүжүүлэхгүй байх, хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн байршуулах, иргэд, олон нийтийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг удирдлага, албан хаагчдад танилцуулж хэвших, дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээний чиг үүргийг тус тусад нь хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.	
5	Засгын газрын тогтоол батлах "Дүрэм тухай" 2019.01.23-ны өдрийн №33	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"	Албаны ёс зүйн зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 2 зорилт 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжилтийг ханган ажиллаласан. Тухайлбал: ➤ Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/14 тоот тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан. ➤ "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх" сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа. ➤ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг албаны https://sankhuu.orkhon.gov.mn/ цахим сайт, албаны дундын групп-т тус тус байршуулж, албан хаагчдад танилцуулж ажиллалаа. ➤ Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл, Төрийн албаны зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад албаны дарга, ёс зүйн дэд хорооны дарга, гишүүн, хяналт-	100%

			шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар танхимаар, бусад албан хаагчид цахимаар хамрагдсан. ➤ 2024 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл ирээгүй болно. ➤ “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг 6-р сард зохион байгуулж ажиллана. ➤ 2024 оны эхний хагас жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь гаргаж, ХШҮХМ-д хүргүүлсэн.	
6	Журам шинэчлэн батлах тухай 2016-01-11 №29	Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйл 8.5-д /Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана/	Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Журамд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд иж бүрэн үнэн зөв байршуулсан эсэхэд дотоод аудит гүйцэтгэн, үр дүнг аймгийн дотоод аудитын хороонд тайлагнаж, улирал бүр Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт Эрсдлийн удирдлагын газарт хүргүүлэн ажиллаж байна.	100%
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 2021.12.14 №64	14.5.2 Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зайлшгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийх, хяналт шалгалтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх	Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 2 удаагийн хяналт шалгалт хийгдлээ. 1. Аймгийн ЗДТГ-н Хууль, эрх зүйн хэлтсээс манай албанд цохож ирүүлсэн иргэн Б.Нямжаргалын өргөдөл гомдлын дагуу аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/24 тоот “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт” хийх удирдамжийн дагуу Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт 2. Сангийн Сайдын баталсан 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн СХШХ/03 дугаар “ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА ГААЛИЙН ГАЗАР, ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ХЯНАЛТ	100%

		шатны Засаг дарга нарт даалгав.	ШАЛГАЛТЫН НЭГДСЭН УДИРДАМЖ”, аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 17/24 дугаар удирдамжийн дагуу “Орхон аймаг дахь Гаалийн газар”-ын 2022, 2023 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг тус тус гүйцэтгэлээ.	
8		14.5.3 Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн хяналт шалгалтыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 50 хувиар бууруулах чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлэхийг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөв.	Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хувьцаат компани болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх 2024 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан бөгөөд тус онд нийт 60 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх бөгөөд үүний 32 байгууллагад дотоод аудит гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Эхний хагас жилд иргэн, аж ахуй нэгжид чиглэсэн хяналт шалгалт хийгдээгүй болно. Цаашид заалтын хэрэгжилтийг ханган ажиллана.	100%
9	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол /Журам батлах тухай 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн	Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллах.	Байгууллагын даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/02 дугаар тушаалаар өмч хамгаалах зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй томилсон. Өмч хамгаалах зөвлөлөөс байгууллагын эд хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад байнгын тогтмол хяналтыг тавин ажиллаж байна.	100%

	159 дугаар тогтоол/			
	Хуралдааны тэмдэглэл 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 02 дугаар тэмдэглэл	Заалт-1.2: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагуудын шилэн дансны ашиглалт, хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүн, тайланг улирал бүр Ажлын албанд ирүүлэх, мөн тухайн дүнг танилцуулах хэлбэрийг өөрчилж, байгууллагуудын удирдлагуудыг хамруулан зохион байгуулдаг болох, шилэн дансны хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, тогтмолжуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2023 оны 01 дүгээр сард багтаан Ажлын албанд ирүүлэх	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд: ➤ Шилэн дансны тухай хуулийн 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлж ажиллалаа. Оны эхний хагас жилд: ➤ “Цахим системийн шинэчлэл, мэдээлэл байршуулахад анхаарах зарим асуудал сэдэв”-т сургалтыг цахимаар зохион байгуулж, Сургалтад Орон нутгийн өмчит төсөвт байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит хувьцаат компани, Орон нутгийн тусгай сан, аймаг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг нийт 84 байгууллагын 50 мэдээлэл оруулагч, нягтлан бодогчид хамрагдлаа. ➤ Оюу цэцэрлэг, Жаргалант сумын Эрүүл мэндийн төв, 16 дугаар сургууль, 18 дугаар цэцэрлэг, Уран эгшиг сургааль зэрэг байгууллагуудын 5 нягтлан бодогчид ажлын байранд, 24 байгууллагын нягтлан бодогчид утсаар болон зөвлөгөө, мэдээллийг өгч арга зүйгээр хангаж ажиллалаа. ➤ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, тогтмолжуулах зэрэг ажлуудыг зохион байгуулах гэсэн үүрэг даалгаврын хүрээнд: ➤ Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, мэдээлэл оруулагч нарт Шилэн дансны нэгдсэн цахим хуудас-СХДАА, Орхон Төрийн сан зэрэг цахим хуудсаар дамжуулан Шилэн дансны цахим системийн шинэчлэл, мэдээлэл байршуулалттай холбоотой 8 удаагийн зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажиллалаа. Мөн албаны www.Sankhuu.audit.or.qov.mn сайтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хийгдсэн дотоод аудитын мэдээллийг тогтмол байршуулж байна.	100%

			➤ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн 2023 оны нэгдсэн дотоод аудитын дүн, мэдээг Орон нутгийн Тусгал телевизээр 1 удаа иргэд, олон нийтэд хүргэсэн. Орхон аймгийн ЗДТГ-н Хууль, эрхзүйн хэлтэс орон нутгийн Номин телевизтэй хамтран явуулдаг “Хуулийн цаг” нэвтрүүлэгт оролцон мэдээлэл хүргэсэн.	
	Журам батлах тухай 2017 оны 04 дүгээр сарын 28 – ны өдрийн 49 дугаар тогтоол	Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах.	Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 71,72,73 дугаар зүйл, Засгийн газрын 2020оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 9 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 64 дүгээр тогтоол, Албаны даргын тушаалаар тооллогын комиссыг томилж, эхний хагас жилийн тооллогыг хийж дутагдсан, эвдэрсэн хөрөнгө байгаагүй бөгөөд энэ онд элэгдлийн хугацаа дуусч ашиглалтаас хасах хөрөнгө байхгүй болно.	100%
	Аймгийн засаг даргын захирамж /2018 оны А/233 дугаар захирамж/	“Албаны дүрэм, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам”		
	Монгол улсын сангийн сайд орхон аймгийн засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3.37, 3.38 3.39, 3.40, 4.2 заалтууд хамраална.	3.38. “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, биелэлтийг улирал бүрийн эцэст Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	“Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу эхний хагас жилийн тоон мэдээ, бичмэл тайланг 2024 оны 07 дугаар 10-ны өдрийн дотор Монгол Улсын Сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.	100%

		байгууллагад ирүүлж ажиллана.” заалт		
		3.38. “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитуудыг дотоод аудитын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулна.” заалт	Албаны Нэгдсэн менежментийн тогтолцоонд Чанарын дотоод аудит гүйцэтгэх Чанарын Дотоод аудитораар 1 албан хаагчийг даргын тушаалаар томилсон. Стандартын шаардлагын хүрээнд Чанарын Дотоод аудитор нь “Менежментийн тогтолцооны аудитын заавар” MNS ISO 19011:2020 стандартын сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байхыг шаарддаг. Энэ хүрээнд Стандарт хэмжил зүйн газрын Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төвөөс зохион байгуулсан “MNS ISO 19011:2020 Менежментийн тогтолцоонд аудит явуулах заавар” стандартын сургалтад Чанарын Дотоод аудиторыг хамрууллаа. Тус сургалтын зорилго нь “Байгууллагын менежментийн тогтолцоонд дүн шинжилгээ хийх, байнгын сайжруулалт хийхийн тулд дотоод аудитыг төлөвлөх, аудитын шалгуур бодит нотолгоог цуглуулах, үл тохирлыг илрүүлэх, холбогдох арга хэмжээг авах, аудитыг тайлагнах, арга зүйн заавраар хангах аудитын арга техникийг шинэчлэгдсэн стандартын гүйцэтгэх мэдлэг чадварын олгох юм. Монголын Мэргэшсэн Нягтлан бодогчдын Институтээс 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрүүдийн хооронд зохион байгуулсан 120 цагийн “Аудиторын сургалт”-д 1 Дотоод аудитор хамрагдан амжилттай суралцаж, №1776 дугаартай гэрчилгээ авсан.	100%
		3.39. “Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал,	Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоода аудитын дүрмийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.	100%

		хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” заалт	Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хорооны даргаар батлуулан, дараах 4 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ. Үүнд: 1. 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, 2. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (2023 он, 2024 оны I улирал) 3. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор байгууллагын нэршил өөрчлөгдсөн, Сангийн сайдын 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг шинээр баталсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм”, Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийг төслөөр тусган хэлэлцүүлэх, батлуулах; 4. Бусад асуудал (2023 онд хийсэн онцлох ажлууд) Хорооны хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”, Дотоод аудит хийх журам”-ын төслийг гишүүдийн 100%-ийн саналаар дэмжин Аймгийн Дотоод аудитын хорооны хурлын 01/24 дүгээр тогтоолоор “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Дотоод аудит хийх журам”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-ыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.	
		3.40. “Дотоод аудитын нэгдсэн системийг нэвтрүүлэх, дотоод аудит санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлэх, шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлж ажиллана.” заалт	2024 онд Монгол Улсын Сангийн Яамнаас улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг Олон улсын шилдэг туршлага, нийтлэг практикт нийцүүлэх, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор улсын салбарын бусад мэдээллийн системтэй уялдсан, вебд суурилсан Дотоод аудитын удирдлагын мэдээллийн системийг үе шаттай хөгжүүлэн нэвтрүүлж эхэлсэн. Аймаг, нийслэл, дүүргүүдийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Дотоод аудит, Санхүүгийн хяналт шалгалтын жилийн төлөвлөгөө, тайлан, танилцуулга, ажлын баримтууд, засаглал, эрсдэл,	100%

			дотоод хяналтын удирдлагын бүхий л мэдээллийг уг системд иж бүрэн байршуулж ажиллах үүрэг хүлээн ажилладаг. Дээрх үйл ажиллагааг Сангийн сайд Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.40-д “дотоод аудитын нэгдсэн системийг нэвтрүүлэх, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахим системд шилжүүлэх, шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлэн ажиллана” гэж заасан. Тус заалтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст албанд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэн 2024 оны 04 дүгээр сард 47 дугаартай албан бичгээр, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт тус тус хүсэлтийг хүргүүлсэн. Албаны хэмжээнд удирдлагын түвшинд 1,895.0 мянган төгрөгийн төсвийг шийдвэрлэн суурийн компьютерийн 2 ш дэлгэц, 1 ш олон үйлдэлт өнгөт принтерийг худалдан авч, албан хаагчдын ажил үүргээ хурдан шуурхай гүйцэтгэх нөхцөлийг сайжруулж, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж ажилласан. Албанд бүртгэлтэй, албан хаагчдын ашиглаж буй компьютер, тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул 2025 оны “Төсвийн төсөл”-д 46,333.2 мянган төгрөгийн төсвийг нэмж тусган хүргүүлж ажилласан.	
		4.2. “Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана”	Сангийн сайд Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 4 дүгээр бүлгийн 4.2-т “Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана” гэсэн заалт, 2024 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус ханган “Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан”-ийн 2023 оны санхүү, үйл ажиллагаанд Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Дотоод аудитын олон улсын стандартын дагуу төлөвлөгөөт дотоод аудитыг Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр баталсан №24/24 дугаартай Дотоод аудитын удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.	100%

			Дотоод аудитаар Жаргалант сумын Иргэдийн төлөлөгчдийн хурлаар Багуудын Иргэдийн Нийтийн хурлаас ирүүлсэн саналыг эрэмбэлэн 2023 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, 80%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна. Энэ удаагийн дотоод аудитаар сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Болзошгүй аваарын зардал” гэж хуваарилан хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт болон орон нутгийн иргэдийн саналын эрэмбэд ороогүй дараах 12 ажлын гүйцэтгэлд нийт 209,009.4 мянган төгрөгөөр зарцуулсан, 2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн мэдээлээгүй, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, удирдамжгүйгээр хяналт шалгалтыг зохион байгуулсан зэрэг 3 зөрчил илэрсэн тул тус сангийн 2023 оны үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэн Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн 1 албан шаардлага, ажил сайжруулах 3 зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцож ажилласан байна. Мөн байгууллагын “засаглал”-ын төлөвшлийг 3 дугаар төвшин буюу “томьёолсон” түвшинд, “эрсдэлийн удирдлага”, “дотоод хяналт”-ын үйл явцын төлөвшлийг 2 дугаар түвшин буюу “давтамжтай” түвшинд байна гэж дүгнэн цаашид аудитаар илэрсэн асуудалд анхаарч, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилтийг ханган ажиллах, хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд иж бүрэн байршуулах, иргэд, олон нийтийг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг удирдлага, албан хаагчдад танилцуулж хэвших, дотоод хяналт, хяналт шинжилгээ үнэлгээний чиг үүргийг тус тусад нь хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсөн байна.	
Биелэлтийн хувь:				100%
2.3.ХАРИЛЦАГЧ СУБЪЕКТТАЙ ЧИГ ҮҮРГИЙН ХАМААРЛЫН ХҮРЭЭНД:				
	Төсвийн ерөнхийлөн	Төсвийн захирагчийн	ерөнхийлөн эрхлэх	100%

	захирагч буюу аймгийн Засаг дарга	асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж гүйцэтгэх	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж байна. Үүнд: ➤ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. “Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх”, 14.2.10 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” заалт, Тус хуулийн 69 дүгээр зүйл. “Дотоод аудит”. 69.1 “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” гэсэн заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
	Сангийн яам, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр хүргүүлэх, мөн СХШУБ-ийн эрх олгох, СХШУАБ, СХШУБ, Дотоод аудитуудыг сургалт, мэдээ мэдээллээр хангах	Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, 69.2 дахь заалтаар “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тоон тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр Сангийн яамны эрсдэлийн удирдлагын газарт, Сангийн сайд, Орхон аймгийн Засаг даргын 2024 онд хамтран ажиллах гэрээний эхний хагас жилийн биелэлтийг холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.	100%
	Аймгийн Дотоод аудитын хороо	Дотоод аудитын хорооны нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг	Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хорооны даргаар батлуулсан, дараах 4 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ. Үүнд:	100%

		хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх.	- 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, - Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (2023 он, 2024 оны I улирал) - Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор байгууллагын нэршил өөрчлөгдсөн, Сангийн сайдын 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг шинээр баталсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжаар баталсан “Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм”, Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийг төслөөр тусган хэлэлцүүлэх, батлуулах; - Бусад асуудал (2023 онд хийсэн онцлох ажлууд) Хорооны хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”, Дотоод аудит хийх журам”-ын төслийг гишүүдийн 100%-ийн саналаар дэмжин Аймгийн Дотоод аудитын хорооны хурлын 01/24 дүгээр тогтоолоор “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм”, “Дотоод аудит хийх журам”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-ыг тус тус батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна.	
	Аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс, газар, агентлаг	Удирдах дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилт, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах.	Оны эхний хагас жилийн байдлаар удирдах дээд байгууллагаас 150 албан бичиг ирснээ 51 нь хариутай бичиг ирсэн. Хариутай ирсэн бичгийг холбогдох заасан хугацаанд хүргүүлж ажилласан. Хугацаа хэтэрсэн болон шийдвэрлээгүй албан бичиг байхгүй.	100%
	Төрийн албаны зөвлөлийн Орхон	Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх, хүний нөөц болон	Энэ онд Төрийн захиргааны 2 албан тушаалд сул орон тоо гарсан байна. 1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	100%

	аймаг дахь салбар зөвлөл	бусад мэргэшүүлэх сургалтад хамрагдах.	2. Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс шилжүүлэн авч ажиллуулах зарыг “Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл”-д хүргүүлж ажилласнаар тус салбар зөвлөл хуульд заасан хугацаанд “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай” зарыг https://erdenet.mn/- сайтад байршуулсан. Манай алба тус зарыг өөрийн байгууллагын https://sankhuu.orkhon.gov.mn/- сайтдаа байршуулж ажилласан. ➤ Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн албан тушаалын зарыг 2024.05.28-ны өдрөөс 2024.06.05-ны өдрийн 17:00 цаг хүртэл материал хүлээн авахад Баян-Өндөр сумын ЗДТГ-т Худалдан авах ажиллагаа, өмч хариуцсан мэргэжилтэн П.Даваажаргал шилжин ажиллах хүсэлт, холбогдох материалыг ирүүлсэн. ➤ Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч албан тушаалын зарыг 2024.08.28-ны өдрөөс 2024.09.02-ны өдрийн 17:00 цаг хүртэл материал хүлээн авахад Булган аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч албан тушаалтай П.Азхишиг шилжин ажиллах хүсэлт, холбогдох материалыг ирүүлсэн. Тус 2 албан тушаалд ажиллах хүсэлт гаргасан албан хаагчдын материалтай танилцаж, шаардлага хангасан тул 2 албан тушаалтны шилжүүлэн авч ажиллуулсан. “Төрийн албаны салбар зөвлөл”-өөс зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчид цахимаар хамрагдсан. Үүнд: ✓ Төрийн албачн хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн танилцуулга- 2024.03.07 ✓ “Дижитал шилжилт, Виртуал орчинд ажиллах”-2024.03.14 ✓ Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II” сэдэвт сургалт – 2024.03.28	
--	--------------------------	--	---	--

			✓ Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Төрийн албаны шинэчлэл: Шинэ 30 жил” сэдэвт сургалт- 2024.09.02 ✓ “ТАЦНС-н шинэ хөгжүүлэлттэй холбоотой дэмжлэг үзүүлэх” сэдэвт сургалт-2024.09.05 ✓ “Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж үр дүн” сэдэвт сургалт- 2024.09.12 ✓ "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого" богино хугацааны сургалтад 10 албан хаагч цахимаар болон танхимаар 100% хамрагдаж гэрчилгээ авсан. Мөн Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл, Төрийн албаны зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж уг сургалтад Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, ТАЗ-ийн ССМНСГ-ын хэлтсийн дарга С.Батнасан, ТАЗ-ийн МХШГ-ын ахлах референт Р.Жавзандулам нар мэдээлэл өгсөн.	
Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд	Төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, гарсан зөрчлийг арилгуулах	2024 оны Дотоод аудит, СХШ-н төлөвлөгөөгөөр 61 байгууллага шалгахаас эхний хагас жилд 34 байгууллага шалгасан буюу төлөвлөгөөний гүйцэтгэл 56%-тай байна. Дотоод аудитаар 19 байгууллага, Санхүүгийн хяналт шалгалтаар 15 байгууллагын шалгалтад хамруулсан байна. Хяналт шалгалт гүйцэтгэсэн 34 байгууллагуудад эрсдлийн үнэлгээг хийхэд Их эрсдэлтэй-1, Дунд эрсдэлтэй-15, бага эрсдэлтэй-18 гэж үнэлэгдсэн байна. 2024 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2 улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит, 17 байгууллагад дотоод аудитыг Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын секторын дотоод аудитын аргачлал”-ын дагуу, 15 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх стандарт”-ын дагуу тус тус гүйцэтгэн албаны даргын тушаалаар баталсан “Эрсдэлийн менежментийн журам”-аар	100%	

			эрсдэлийг үнэлэн зөвөлгөө өгч, нөхөн төлбөрийн акт, зөрчил таслан зогсоох албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. ➤ Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл <table border="1"> <tr> <th rowspan="2">Хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагын тоо</th><th colspan="2">Шалгалтын төрөл</th><th colspan="2">Шалгалтын хэлбэр</th></tr> <tr> <th>Төлөвлөгөө өт</th><th>Төлөвлөгөө өт бус</th><th>Дотоод аудит</th><th>СХШ</th></tr> <tr> <td>34</td><td>32</td><td>2</td><td>19</td><td>15</td></tr> </table> 2024 оны эхний хагас жилийн байдлаар Улсын төсөвт үйлдвэрийн газар-1, Төсвийн байгууллага-27, ОНӨААТҮГ-3, Засгийн газрын тусгай сан-1, Бусад /ТБ/-2 нийт 34 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн бөгөөд “Хангалттай” үнэлэгдсэн 6 байгууллага, “Хангалттай бус” үнэлэгдсэн 11 байгууллага, “Сайжруулах шаардлагатай” үнэлэгдсэн 14 байгууллага байна. Төлөвлөгөөт бусаар гүйцэтгэсэн 1 шалгалтад зөрчлийг танилцуулж ажилласан байна.	Хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагын тоо	Шалгалтын төрөл		Шалгалтын хэлбэр		Төлөвлөгөө өт	Төлөвлөгөө өт бус	Дотоод аудит	СХШ	34	32	2	19	15	
Хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагын тоо	Шалгалтын төрөл		Шалгалтын хэлбэр															
	Төлөвлөгөө өт	Төлөвлөгөө өт бус	Дотоод аудит	СХШ														
34	32	2	19	15														
	Иргэн, олон нийтийн байгууллага, холбогдох бусад байгууллагууд	Өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, шилжүүлэх	2024 оны эхний хагас жилийн байдлаа албаны хэмжээнд 21 өргөдөл хүсэлт ирсэн байна. Үүнд: ➤ Албан хаагчдаас ирсэн-17 ➤ Албанд гаднаас ирсэн-4 байна. Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт хуулийн хугацаанд 100% шийдвэрлэсэн. Албан хаагчдаас болон албанд хандсан гомдол санал ирээгүй.	100%														
				100%														
				100%														

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР